



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/817 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны А/133 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс 24-ний өдөр хүртэл дүүрэгт орсон борооны улмаас Биеийн тамир, спортын хорооны дээврээс ус гоожиж хэвийн үйл ажиллагаа алдагдсан тул дээврийн хэсэгчилсэн засварын ажлыг гүйцэтгэсүгэй.

2.Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Дээврийн засварт шаардагдах 3,311,000 (Гурван сая гурван зуун арван нэгэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 07 дүгээр сарын 27 ны өдрийн
А.М.С. дугаар захирамжийн хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДЭЭВЭРИЙН ЗАСВАРТ
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Чулуугүй цаас наадаг	м	15	96,000	1,440,000
2	Чулуутай хар цаас	м	9	76,000	684,000
3	Битум	ш	2	86,000	172,000
4	Цемент	ш	15	25,000	375,000
5	Элс	т	2	150,000	150,000
6	Хайрга	т	2	150,000	150,000
7	Дизель түлш	л	100	3400	340,000
Нийт дүн:					3,311,000